

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/57/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:51-261665 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Чанцалдулам Утас:51-260512 Цахим хаяг: <a href="mailto:chantsaldulamp@audit.gov.mn">chantsaldulamp@audit.gov.mn</a> Аудитор: Г.Тэлмүүн Утас: 51-261885 Цахим хаяг: <a href="mailto:telmuung@audit.gov.mn">telmuung@audit.gov.mn</a> Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал: С.Тунгалаг Утас: 7001778 Цахим хаяг: <a href="mailto:info@imkaudit.mn">info@imkaudit.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>2</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>10</b>
3.1 Компани, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Компанийн гадаад, дотоод орчин .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт .....	11
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл .....	13
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл .....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>16</b>
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....</b>	<b>19</b>
5.1 Төлбөрийн акт .....	20
5.2 Албан шаардлага .....	20
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>22</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЦХИХХЯ	Цахим хөгжил инновац, харилцаа холбооны яам



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ  
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
С.АДЪЯАСҮРЭН ТАНАА

2026.03.16 № 06/637  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын үндсэн сүлжээ 59,500 км орчим шилэн кабелийн урттай болж, аймаг, сумдын 98% нь дижитал холболтоор хангагдан, 2025 онд нийт 331 сумаас 329 сум бүрэн шилэн кабелийн сүлжээнд холбогдсон байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11/01 дүгээр тогтоолоор гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосон байна.

### Аудитын гол асуудал

Нийслэлийн засаг даргын 2025 оны А/139, А/749 захирамжийн дагуу Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэх “Улаанбаатар хотын нийтийн төв номын сан”-ийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангаж, барилга барих газрын доорх Мэдээлэл холбооны 168 метр хоолой бүхий 2,352 метр 19 ширхэг шилэн болон физик кабелийг нүүлгэн шилжүүлэх, Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд зохион байгуулагдах “Цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагуудын 17 дугаар бага хурал”-ын түр байгууламжийг холбоожуулах гадна холбооны дэд бүтцийн ажлуудад 978.5 сая төгрөгийн зардал гарсан байна.

## Бусад асуудлын хэсэг

Төрийн аудитын байгууллага нь АДБОУС-ын стандартын дагуу аудитын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2025 оны 1-р сарын 1	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,389,755,120.42	3,058,321,149.13
1.1.2	Дансны авлага	10,591,178,079.45	16,838,278,157.72
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	442,532,143.72	270,106,444.03
1.1.4	Бусад авлага	399,572,457.44	562,881,452.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	4,102,073,386.41	4,238,168,523.70
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,466,689,926.03	2,205,266,606.61
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>21,391,801,113.47</b>	<b>27,173,022,333.19</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	123,963,947,736.20	117,618,212,345.41
1.2.2	Биет бус хөрөнгө	55,344,266,582.74	55,015,472,085.75
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	2,795,301,609.00	2,634,193,911.25
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	114,992,727.27	4,046,141,069.52
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>182,218,508,655.21</b>	<b>179,314,019,411.93</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>203,610,309,768.68</b>	<b>206,487,041,745.12</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	2,810,459,031.91	2,988,757,124.86
2.1.1.2	Цалингийн өглөг	-	971,074,460.01
2.1.1.3	Татварын өр	917,681,094.21	1,476,955,520.96
2.1.1.4	НДШ - ийн өглөг	173,761,473.80	5,382,085.73
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,197,483.79	723,910,434.99
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	899,349,395.57	1,543,006,397.34
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>4,810,448,479.28</b>	<b>7,709,086,023.89</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	31,861,150,956.27	29,737,073,025.89
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,039,965,877.94	4,246,800,229.17
2.1.2.5	Хойшлогдсон орлого	32,962,857,952.21	30,744,027,275.53
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>68,863,974,786.42</b>	<b>64,727,900,530.59</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>73,674,423,265.70</b>	<b>72,436,986,554.48</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		-
2.3.1	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	16,087,046,321.35	16,087,046,321.35
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	66,175,258,324.60	67,683,834,462.05
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(89,877,912,854.51)	(87,272,320,304.30)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>129,935,886,502.98</b>	<b>134,050,055,190.64</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>203,610,309,768.68</b>	<b>206,487,041,745.12</b>

**2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	64,871,865,398.18	79,781,772,944.66
2	Борлуулалтын өртөг	55,477,664,229.70	68,816,140,729.84
<b>3</b>	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>9,394,201,168.48</b>	<b>10,965,632,214.82</b>
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	13,526,825.43	17,352,999.99
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	2,228,641,597.02	2,307,569,671.27
9	Борлуулалт, маркетингийн зардал	557,542,884.47	563,634,545.85
10	Ерөнхий ба удирдлагын зардал	6,146,652,412.88	5,139,858,050.10
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	3,229,038,057.06	3,157,595,673.63
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(54,728,980.96)	(35,528,615.07)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	260,530,357.95	9,936,363.64
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг ( алдагдал)	-	-
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>1,908,937,613.51</b>	<b>4,403,874,365.07</b>
19	Орлогын татварын зардал	330,536,170.91	882,540,239.60
19.1	Хойшлогдсон татварын зардал	116,284,982.76	184,683,345.26
<b>20</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>1,462,116,459.84</b>	<b>3,336,650,780.21</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>1,462,116,459.84</b>	<b>3,336,650,780.21</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
26	Бусад олз (гарз)	-	-
<b>27</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>1,462,116,459.84</b>	<b>3,336,650,780.21</b>
<b>28</b>	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

**2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,115,545,818.58</b>	<b>63,732,485,940.51</b>	<b>(90,998,550,751.58)</b>	<b>126,400,975,719.05</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	28,499,497.23	<b>28,499,497.23</b>
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,115,545,818.58</b>	<b>63,732,485,940.51</b>	<b>(90,970,051,254.35)</b>	<b>126,429,475,216.28</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	1,462,116,459.84	<b>1,462,116,459.84</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	2,442,772,384.09	-	<b>2,442,772,384.09</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	(369,978,060.00)	<b>(369,978,060.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(28,499,497.23)	-	-	<b>(28,499,497.23)</b>
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,087,046,321.35</b>	<b>66,175,258,324.60</b>	<b>(89,877,912,854.51)</b>	<b>129,935,886,502.98</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,087,046,321.35</b>	<b>66,175,258,324.60</b>	<b>(89,877,912,854.51)</b>	<b>129,935,886,502.98</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	3,336,650,780.21	<b>3,336,650,780.21</b>
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	1,508,576,137.45	-	<b>1,508,576,137.45</b>
Зарласан ногдол ашиг	-	-	-	(731,058,230.00)	<b>(731,058,230.00)</b>
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,087,046,321.35</b>	<b>67,683,834,462.05</b>	<b>(87,272,320,304.30)</b>	<b>134,050,055,190.64</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	68,322,926,966.14	81,387,601,443.03
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	68,013,178,584.62	80,960,080,890.57
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,708,262.40	60,949,517.06
	Бусад мөнгөн орлого	303,040,119.12	366,571,035.40
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	57,029,471,869.43	68,803,142,766.05
	Ажиллагчдад төлсөн	21,811,513,953.12	25,545,395,982.08
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	6,038,117,741.90	7,525,387,828.85
	Бараа материал худалдан авахад төлсөн	2,299,792,118.40	2,349,627,704.87
	Ашиглалтын зардалд төлсөн	13,055,071,738.57	17,856,261,292.56
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,264,731,540.02	3,846,064,468.41
	Хүүний төлбөрт төлсөн	761,514,412.63	1,047,980,729.57
	Татварын байгууллагад төлсөн	6,368,447,369.09	8,717,099,521.01
	Даатгалын төлбөрт төлсөн	64,005,562.85	81,192,612.31
	Бусад мөнгөн зарлага	3,366,277,432.85	1,834,132,626.39
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>11,293,455,096.71</b>	<b>12,584,458,676.98</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	440,448,402.74	24,332,999.99
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	427,045,000.00	6,980,000.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	13,403,402.74	17,352,999.99
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	7,691,629,331.59	11,088,820,871.45
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	7,329,003,977.84	10,924,615,370.45
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	362,625,353.75	164,205,501.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(7,251,180,928.85)</b>	<b>(11,064,487,871.46)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	3,800,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	3,800,000,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,494,055,990.38	6,655,136,160.38
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,124,077,930.38	5,924,077,930.38
	Төлсөн ногдол ашиг	369,978,060.00	731,058,230.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,494,055,990.38)</b>	<b>(2,855,136,160.38)</b>
<b>4</b>	<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(53,240,330.16)</b>	<b>(3,731,383.57)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>1,494,977,847.32</b>	<b>(1,331,433,971.29)</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>2,894,777,273.10</b>	<b>4,389,755,120.42</b>
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>4,389,755,120.42</b>	<b>3,058,321,149.13</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 он Гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</b>			<b>67,539,432.1</b>	<b>75,011,923.0</b>	<b>82,273,804.0</b>	<b>14,734,371.9</b>	<b>21.8%</b>	<b>7,481,637.7</b>	<b>109.7%</b>
1	Сувгийн үйлчилгээ	м.төг	31,756,732.5	33,376,506.4	39,064,374.8	7,307,642.3	23.0%	5,687,868.4	117.0%
	Улс, хоорондын сүлжээний үйлчилгээ	м.төг	5,514,552.0	5,884,148.5	4,940,214.8	(574,337.2)	-10.4%	(943,933.7)	84.0%
	Худаг сувагчлал	м.төг	5,521,787.0	5,488,822.8	5,869,746.6	347,959.6	6.3%	380,923.8	106.9%
	Байр, талбай, антен түрээс	м.төг	13,272,599.6	16,245,144.0	15,644,703.5	2,372,103.9	17.9%	(600,440.5)	96.3%
	Хэрэглэгчийн шугам	м.төг	240,000.0	240,240.0	240,000.0	-	0.0%	(240.2)	99.9%
	Техник менежмент	м.төг	8,566,194.3	11,101,092.7	14,022,733.2	5,456,538.9	63.7%	2,921,640.5	126.3%
	Үйл ажиллагааны бус орлого	м.төг	2,667,566.7	2,675,968.6	2,492,031.1	(175,535.6)	-6.6%	(183,937.5)	93.1%
2	<b>Нийт орлого</b>	<b>м.төг</b>	<b>67,539,432.1</b>	<b>75,011,923.0</b>	<b>82,273,804.0</b>	<b>14,734,371.9</b>	<b>21.8%</b>	<b>7,261,881.0</b>	<b>109.7%</b>
3	<b>Нийт зардал</b>	<b>м.төг</b>	<b>65,630,494.4</b>	<b>73,000,560.8</b>	<b>77,869,929.7</b>	<b>12,239,435.3</b>	<b>18.6%</b>	<b>4,869,368.9</b>	<b>106.7%</b>
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	796,882.4	795,258.9	1,118,982.0	322,099.6	40.4%	323,723.1	140.7%
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>м.төг</b>	<b>1,908,937.6</b>	<b>2,011,362.3</b>	<b>4,403,874.4</b>	2,494,936.8	130.7%	2,392,512.1	218.9%
5	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>м.төг</b>	<b>1,462,116.5</b>	<b>1,561,811.8</b>	<b>3,336,650.8</b>	<b>1,874,534.3</b>	<b>128.2%</b>	<b>1,774,839.0</b>	<b>213.6%</b>
6	<b>Төсвийн төлбөрт нийт дүн</b>	<b>м.төг</b>	<b>12,406,564.9</b>	<b>12,645,090.5</b>	<b>16,236,132.9</b>	<b>3,829,568.0</b>	<b>30.9%</b>	<b>3,591,042.4</b>	<b>128.4%</b>
	а/ Орлогын татварт	м.төг	361,229.3	259,509.5	294,921.6	(66,307.7)	-18.4%	35,412.1	113.6%
	б/ НӨАТ	м.төг	3,139,617.1	3,612,000.0	5,320,642.1	2,181,025.0	69.5%	1,708,642.1	147.3%
	в/ НДШ	м.төг	6,038,117.7	6,355,163.6	7,525,387.8	1,487,270.1	24.6%	1,170,224.2	118.4%
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	2,250,433.1	2,139,227.9	2,319,327.0	68,893.9	3.1%	180,099.1	108.4%
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	235,289.5	214,469.5	245,469.0	10,179.5	4.3%	30,999.5	114.5%
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	4,964.4	11,650.0	12,581.3	7,616.9	153.4%	931.3	108.0%
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	376,913.8	53,070.0	517,804.1	140,890.3	37.4%	464,734.1	975.7%
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	369,978.1	436,554.6	731,058.0	361,079.9	97.6%	294,503.4	167.5%
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	1,314	1,346	1,268	(32)	-5.8%	(78)	94.2%
9	Нийт цалингийн сан	м.төг	22,123,448.0	26,487,867.6	26,472,496.3	4,349,048.3	19.7%	(15,371.3)	99.9%
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	1,403.1	1,639.9	1,739.8	336.7	24.0%	99.9	106.1%

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	1.0	1.0	1.0	(0.0)	-1.0%	(0.0)	99.0%
12	Хөрөнгө оруулалт	м.төг	6,826,235.2	10,985,235.3	9,957,789.3	3,131,554.1	45.9%	(1,027,446.0)	90.6%
13	<b>Нийт авлага</b>	<b>м.төг</b>	<b>10,591,178.1</b>	<b>8,729,059.5</b>	<b>16,838,278.2</b>	<b>6,247,100.1</b>	<b>59.0%</b>	<b>8,109,218.7</b>	<b>192.9%</b>
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-			
14	<b>Нийт өглөг</b>	<b>м.төг</b>	<b>40,711,565.3</b>	<b>36,046,285.4</b>	<b>37,446,159.0</b>	<b>(3,265,406.3)</b>	<b>-8.0%</b>	<b>1,399,873.6</b>	<b>103.9%</b>
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	4,810,448.5	2,434,039.9	7,709,086.0	2,898,637.5	60.3%	5,275,046.1	316.7%
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	35,901,116.8	33,612,245.5	29,737,073.0	(6,164,043.8)	-17.2%	(3,875,172.5)	88.5%

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Компани, түүний үйл ажиллагаа**

Компанийн үндсэн зорилт нь Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарыг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, Хувьцаа эзэмшигчийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж ашгийн төлөө ажиллаж, өөрийгөө бүрэн санхүүжүүлэхэд оршино.

Компани нь дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

- Хот , хот хоорондын харилцаа холбооны дамжуулах суваг, сүлжээний түрээсийн үйлчилгээ;
- Интернэтийн бөөний болон олон улсын интернэтийн дамжуулах үйлчилгээ;
- Харилцаа холбооны хэрэглэгчийн шугамын үйлчилгээ;
- Тоног төхөөрөмжийн байр, цамхаг, байр талбайн түрээсийн үйлчилгээ;
- Харилцаа холбооны худаг сувагчлалын түрээсийн үйлчилгээ;
- Техник менежментийн үйлчилгээ;
- Мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйл ажиллагаа;
- Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх үйл ажиллагаа;
- Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ;
- Радио давтамж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийх, лабораторийн үйл ажиллагаа;
- Бусад сургалтын үйл ажиллагаа;

Компани нь үндсэн үйл ажиллагаанаас гадна хуулиар хориглоогүй бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болно. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагаа явуулахдаа эрх бүхий байгууллагаас зохих зөвшөөрөл авч холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлнэ. Хуульд заасан эрх бүхий байгууллагын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд компани нь үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дүрэмд өмчийг 100 хувь төр эзэмшдэг ба төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллага болох Эрчист Монгол ХХК хэрэгжүүлэхээр заасан байна.

#### **3.2 Компанийн гадаад, дотоод орчин**

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК нь хот, хот хоорондын харилцаа холбооны дамжуулах суваг, сүлжээний түрээс, интернэтийн бөөний болон олон улсын интернэтийн дамжуулах, харилцаа холбооны хэрэглэгчийн шугам, тоног төхөөрөмжийн байр, цамхаг, байр талбайн түрээс, харилцаа холбооны худаг сувагчлалын түрээс, техник менежментийн зэрэг үйлчилгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ, радио давтамж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийх, лаборатори болон бусад сургалтын үйл ажиллагааг явуулдаг, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компани нь Харилцаа холбооны тухай хууль, Инновацийн тухай, Хувь хүний нууцын тухай, Кебир аюулгүй байдлын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Татварын багц хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Татварын ерөнхий хууль

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Компанийн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналт, шинжилгээний албаны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж 306 заалт бүхий хугацаатай албан даалгавар, 15 зөвлөмж хүргүүлж 81.9 хувиар үнэлсэн байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний дотоод аудитын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийгдээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголтыг олж авснаа дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус Компанийн 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/101 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт**

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,876.7 сая төгрөгөөр буюу 1.4 хувиар өссөн байна.

## Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,389,755.1	3,058,321.1	(1,331,434.0)
Авлага	11,433,282.7	17,671,266.1	6,237,983.4
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,466,689.9	2,205,266.6	738,576.7
Бараа материал	4,102,073.4	4,238,168.5	136,095.1
Үндсэн хөрөнгө	123,963,947.7	117,618,212.3	(6,345,735.4)
Биет бус хөрөнгө	55,344,266.6	55,015,472.1	(328,794.5)
Хойшлогдсон татварын хөрөнгө	2,795,301.6	2,634,193.9	(161,107.7)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	114,992.7	4,046,141.1	3,931,148.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>203,610,309.7</b>	<b>206,487,041.7</b>	<b>2,876,732.0</b>
Өр төлбөр	73,674,423.3	72,436,986.6	(1,237,436.7)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	129,935,886.5	134,050,055.2	4,114,168.7
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>203,610,309.8</b>	<b>206,487,041.8</b>	<b>2,876,732.0</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,058.3 сая төгрөг болж 1,331.4 сая төгрөгөөр буурсан нь авлагын өсөлтөөс шалтгаалан мөнгөн хөрөнгийн нөөц багассан;
- Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 6,238.0 сая төгрөгөөр өссөн нь Монголын цахилгаан холбоо ТӨХК-ийн 7,737.1 сая төгрөг, Жи-Мобайл ХХК-ийн 6,039.5 сая төгрөг, бусад байгууллагаас 1,627.7 сая төгрөг, орон нутгийн болон салбаруудын 1,051.5 сая төгрөг, олон улсын транзит урсгалын төлбөр 894.0 сая төгрөг, ашиглалтын зардлын авлага 61.5 сая төгрөг, нийгмийн татвар НДШ-ийн авлага 270.1 сая төгрөг, бусад авлага 562.9 сая төгрөгт хүрч, найдваргүй авлагын нөөцийг 573.0 сая төгрөгөөр байгуулсантай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 136.1 сая төгрөгөөр өссөн нь нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлын түүхий эд материал буюу холбооны худгийн материал түүний дагалдах хэрэгсэл болох 8,760.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч 8,624.8 сая төгрөгийн бараа материалыг нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлын хүрээнд зарцуулснаас шалтгаалсан;
- Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 738.6 сая төгрөгөөр өссөн нь Хятад улсын Зэт и корпорэшин компанитай МХС/20250302044-01 тоот гэрээний урьдчилгаанд 1,439.1 сая төгрөгийн төлбөр төлж, 700.6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэснээс шалтгаалсан;
- Эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 6,674.5 сая төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ийн 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 660 дугаар тогтоолоор анхны өртгөө нөхсөн ашиглалтын шаардлага хангахгүй 7 нэр төрлийн 142.8 сая төгрөгийн хөрөнгийг актлан, тайлант оны 12,728.5 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан. Тайлант онд худалдаж авсан 5,017.0 сая төгрөг, ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 700 дугаар тогтоолоор Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас 814.1 сая төгрөг, 2025 оны 01

дүгээр сарын 22-ны өдрийн 35 дугаар тогтоолоор ЦХИХХЯ-аас 644.3 сая төгрөг, 2025 оны 10 сарын 09-ны өдрийн 478 дугаар тогтоолоор Засгийн газрын авто бааз ТӨҮГ-аас 34.7 сая төгрөг, 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн Баян-Өлгий аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 264 дүгээр хуралдааны тогтоолын дагуу 7 ширхэг 15.6 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн бэлтгэсэн байна.

- Хойшлогдсон татварын хөрөнгө нь 161.1 сая төгрөгөөр буурсан нь нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хувь тэнцүүлж бүртгэсэн үндсэн хөрөнгийн НӨАТ-ын хүлээн зөвшөөрөлтөөр буурсан;
- Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,931.1 сая төгрөгөөр өссөн нь "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хяналтыг сайжруулах төсөл"-ийн Монгол Улсын хариуцах 5 хувийн урьдчилгааны дүнг шилжүүлснээс шалтгаалсан;
- Дансны өглөг 1,237.4 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх өглөг 28,402.9 сая төгрөг, татвар, НДШ-ийн өглөг 27,784.9 сая төгрөг, бусад өглөг 1,544.1 сая төгрөг, урьдчилж орсон орлого 2,075.7 сая төгрөг, цалингийн өглөг 41,354.4 сая төгрөг, хойшлогдсон татварын өглөг 525.8 сая төгрөгөөр өсөж, байгууллагад өгөх өглөг 28,224.6 сая төгрөг, татвар, НДШ-ийн өглөг 27,393.0 сая төгрөг, бусад өглөг 901.5 сая төгрөг, урьдчилж орсон орлого 1,361.0 сая төгрөг, цалингийн өглөг 40,383.3 сая төгрөг, хойшлогдсон татварын өглөг 2,537.8 сая төгрөг, урт хугацаат зээл 2,124.0 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан.
- Эздийн өмчийн дансны дүн нь 4,114.2 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын тогтоолоор үндсэн хөрөнгө бэлтгэж, тайлант жилийн ашгийн дүнгээр хуримтлагдсан ашиг буурснаас шалтгаалсан байна.

Дээрх эргэлтийн бус хөрөнгийн үлдэгдлээс биет бус хөрөнгийн дансанд 414.0 сая төгрөгийн программ хангамж, 54,601.5 сая төгрөгийн 28.9 сая м<sup>2</sup> газар эзэмших эрх бүртгэлтэй байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

#### **3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монголын мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 722 дугаар тогтоолоор нийт 75,011.9 сая төгрөгийн орлого, 73,000.6 сая төгрөгийн зардал, 1,561.8 сая төгрөгийн цэвэр ашигтай, 9,213.4 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 263 дугаар тогтоолоор тодотгон 10,985.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

### 3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 82,273.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 77,869.9 сая төгрөгийн зардал гарган, 4,403.9 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 82,273.8 сая төгрөг болж төлөвлөснөөс 7,261.9 сая төгрөг буюу 9.7 хувиар давсан нь сувгийн үйлчилгээ, худаг сувагчлал, техник менежментийн орлого нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 77,869.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 4,869.4 сая төгрөг буюу 6.7 хувиар хэтэрсэн байна. Энэ нь борлуулалтын үйл ажиллагааны өртөг 68,816.1 сая төгрөг, Эрчист монгол ХХК-д менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний төлбөрт 583.2 сая төгрөг, найдваргүй авлагын зардал 564.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажилчдын зардал 799.7 сая төгрөг, нийтийн эзэмшлийн явган зам, талбайн тохижилтын ажлын хүрээнд хийгдсэн худаг сувагчлалын ажил 181.5 сая төгрөг, СОР-17 цогцолборын сувагчлалын ажил, бусад захиалгат ажлын өртөг 2,922.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 9 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 9,957.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 4,403.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 2,392.5 сая төгрөгөөр өссөн нь, орлогын төлөвлөгөөг 7,261.9 сая төгрөгийн давуулан биелүүлж, 77,869.9 сая төгрөгийн зардал гарснаас шалтгаалжээ.

Тайлант онд ТӨБЗГ-т 731.1 сая төгрөгийн ногдол ашиг, түрээсийн орлогын 40 хувь буюу 310.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 107/02 дугаар тушаалаар 1346 орон тоотой ажиллахаар дээд хязгаарыг тогтоосноос гүйцэтгэлээр удирдах 54, гүйцэтгэх 1032, үйлчилгээний 182, нийт 1268 орон тоотойгоор ажилласан;
- Байгууллагын 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хамтын гэрээгээр хоол унааны хөнгөлөлтийг Улаанбаатар хотод 6,000.00 төгрөг, Багануур дүүрэг, Налайх дүүрэг, Орхон аймаг, Дархан уул аймагт 5,000.00 төгрөг, бусад аймгийн төвд 4,500.00 төгрөг, сумын төвд 3,000.00 төгрөгөөр баталж, тайлант онд 1,266.0 сая төгрөг төлөвлөснөөс 1,212.0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй;
- Гадаад томилолтоор 14 арга хэмжээнд 170.1 сая төгрөгийг зарцуулсан;
- Компанид нийт 87 ширхэг 2,827.7 сая төгрөгийн программ хангамж бүртгэлтэй;
- Тайлант онд дотоодын хурал зөвлөгөөний 15 арга хэмжээнд 167.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Тайлант онд нээлттэй тендер шалгаруулалтаар 3,864.8 сая төгрөгийн 17 бараа, ажил үйлчилгээг, харьцуулалтын аргаар 848.5 сая төгрөгийн 15 бараа, ажил үйлчилгээ, шууд худалдан авалтаар 3 төрлийн барааг 2,694.7 сая төгрөгөөр худалдан авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системээр 2,694.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 барааг шууд худалдан авалтаар, 848.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 бараа, ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар, 3,864.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар, нийт 8,846.6 сая төгрөгийн 39 бараа, ажил үйлчилгээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан 27 гүйцэтгэгчтэй 3,652.8 сая төгрөгийн гэрээ байгуулж, 1,366.5 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах зардал, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор О.Эрдэнэчимэг, Ш.Солонго, аудитын менежер Г.Ариунболд, нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, дараагийн шатны хяналтыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 11-ны өдрийн 01/06-140 дугаар албан бичгээр 2026 оны 03 дугаар сарын 05-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **Дунд** гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний нийт зардлын 73,000.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 730.0 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор компани, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан тайлант онд хуулиар хориглосон хязгаарласан арга хэмжээг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар илэрсэн нийт 9,509.1 сая төгрөгийн зөрчлөөс 9,509.1 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 62 мэдээлэл байршуулахаас 98.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тус байгууллага нь ахмадын сангийн журамгүйгээр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход 99.1 сая төгрөгийг зарцуулсан нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль тогтоомж, байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн Ахмадын сангийн журам батлуулж мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

2. Шалгагдагч байгууллагуудын орон нутгийн газруудын улсын бүртгэлийн гэрчилгээнд тухайн аймгийн салбар нэрээр бүртгэгдсэн ба албан ёсны хэвлэмэл хуудсанд Газар нэртэй байгаа нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.-т "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгсөн.

3. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 722 дугаар тогтоолоор баталсан " 2025 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нөөс авлагыг 8,109.2 сая төгрөгөөр, өглөгийг 1,399.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-т “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Санхүүгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, үндсэн хөрөнгө, шилэн данс, худалдан авах ажиллагаа, бараа материалын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 1,113.4 сая төгрөгийн 1 алдаа, зөрчлийг залруулж, 4,178.6 сая төгрөгийн 2 зөрчлийг жилийн эцсийн аудитын дүнд нэгтгэсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 79.1 сая төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Зөвлөмж	5	79,123.5	5	79,123.5	100.0
	<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>79,123.5</b>	<b>5</b>	<b>79,123.5</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, тушаал шийдвэрт нийцүүлсэн эсэх, үндсэн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ, түрээсийн байр талбайн эзэмшил, ашиглалтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 21.1 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 21.1 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

*Залруулаагүй алдаа:*

- Байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй Магнайтрейд ХХК-ийн шатахууны талоны үлдэгдлээс 198.0 сая төгрөгийн талоныг ажилчдад борлуулахдаа, татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тайлагнасны улмаас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг Санхүүгийн тайлан болон татварын ТТ02 тайланд 19.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан нь НББОУС12 Орлогын албан татвар 5-д "Татвар ногдуулах ашиг (татварын алдагдал) гэдэг нь татварын эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм журмын дагуу тодорхойлсон тухайн тайлант хугацааны ашиг (алдагдал) бөгөөд үүнд үндэслэн татварыг өглөгийг (буцаан олгох татварыг) тооцоолдог" гэсэнтэй нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Санхүүгийн тайлан болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланг үнэн зөв тайлагнаж байх зөвлөмж өгөх.

- Тайлант онд 9 дүгээр сард 1 ажилтны цалин хөлсийг Нийгмийн даатгалын цахим тайланд тайлагнахдаа 1.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 15-д "Санхүүгийн тайланд аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудын үр нөлөөг Санхүүгийн Тайлагналын Онолын Үзэл Баримтлалд заан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг..." гэсэнтэй нийцэхгүй, Санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Нягтлан бодох бүртгэлийг үндэслэн нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тайлагнах зөвлөмж өгөх.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийт 405.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 403.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 405.3 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 324.7 сая төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Тайлант оны 7 дугаар сард ээлжээр ажилладаг 17 ажилтанд 4.3 сая төгрөгийн баяр ёслолын цагийн хөлс тооцож олгосноос 1.1 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9-т "Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно." гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баяр ёслолын цагийн хөлсийг тооцож олгохдоо илүү олгосон 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

2. Тайлант онд гэрээгээр ажилласан 6 ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт болох 0.9 сая төгрөгийг давхардуулан эдлүүлсэн байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээгээр ажилласан 6 ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлсэн 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд нийт 6 аймгийн 21 байгууллагын 53.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах,"; 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд 5 байгууллагын 6.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хянан, баталгаажуулах;" , 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"; гэж заасныг тус тус мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Жи мобайл ХХК-иас авах хугацаа хэтэрсэн авлагын зарим хэсгийг барагдуулах тухай ТУЗ-ын 2023 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 90/01 дүгээр тогтоолын дагуу авлагын зарим хэсэгт тооцон авсан Магнай трейд ХХК-ийн 600.0 сая төгрөгийн шатахууны талноос, тайлант оны эцэст 344.2 сая төгрөгийн шатахууны талоны зарцуулагдаагүй үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрт авсан шатахууны талоныг дуустал бусад газраас шатахуун худалдан авахыг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй Магнайтрейд ХХК-ийн шатахууны талоны үлдэгдлээс 198.0 сая төгрөгийн талоныг ажилчдад борлуулахдаа, татвар ногдуулах орлогоос хасагдахгүй зардлаар тайлагнасны улмаас Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын зардлыг Санхүүгийн тайлан болон татварын ТТ02 тайланд 19.8 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	19,801.8	-	-	1	19,801.8	-	-	1	19,801.8	1	19,801.8
2	Тайлант онд 9 дүгээр сард 1 ажилтны цалин хөлсийг Нийгмийн даатгалын цахим тайланд тайлагнахдаа 1.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	1,251.8	-	-	1	1,251.8	-	-	1	1,251.8	1	1,251.8
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>21,053.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>21,053.6</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>21,053.6</b>	<b>2</b>	<b>21,053.6</b>

## 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны 7 дугаар сард ээлжээр ажилладаг 17 ажилтанд 4.3 сая төгрөгийн баяр ёслолын цагийн хөлс тооцож олгосноос 1.1 сая төгрөгийн цалинг илүү олгосон байна.	1	1,082.8	1	1,082.8	-	-	-	-	-	-	-	-
2	Тайлант онд гэрээгээр ажилласан 6 ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт болох 0.9 сая төгрөгийг давхардуулан эдлүүлсэн байна.	1	899.5	1	899.5	-	-	-	-	-	-	-	-
3	Тайлант хугацаанд нийт 6 аймгийн 21 байгууллагын 53.2 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	53,216.5	-	-	1	53,216.5	-	-	-	-	-	-
4	Тайлант онд 5 байгууллагын 6.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	5,982.8	-	-	1	5,982.8	-	-	-	-	-	-
5	Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Жи мобайл ХХК-иас авах хугацаа хэтэрсэн авлагын зарим хэсгийг барагдуулах тухай ТУЗ-ын 2023 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн 90/01 дүгээр тогтоолын дагуу авлагын зарим хэсэгт тооцон авсан Магнай трейд ХХК-ийн 600.0 сая төгрөгийн шатахууны талоноос, тайлант оны эцэст 344.2 сая төгрөгийн шатахууны талоны зарцуулагдаагүй үлдэгдэл бүртгэлтэй байна.	1	344,160.0	-	-	1	344,160.0	-	-	-	-	-	-
	<b>Дүн</b>	<b>5</b>	<b>405,341.6</b>	<b>2</b>	<b>1,982.3</b>	<b>3</b>	<b>403,359.3</b>	-	-	-	-	-	-

## 6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Тус байгууллага нь ахмадын сангийн журамгүйгээр ахмадуудад хүндэтгэл үзүүлэх, буцалтгүй тусламж, тэтгэмж олгоход зарцуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
2	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 722 дугаар тогтоолоор баталсан " 2025 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нөөс авлагыг 8,109.2 сая төгрөгөөр, өглөгийг 1,399.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.	1	-	-	-	1	-	-	-
3	Шалгагдагч байгууллагуудын орон нутгийн газруудын улсын бүртгэлийн гэрчилгээнд тухайн аймгийн салбар нэрээр бүртгэгдсэн ба албан ёсны хэвлэмэл хуудсанд Газар нэртэй байна.	1	-	-	-	-	-	1	-
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 163/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд гэрээгээр ажилласан 6 ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт болох 899,527.27 /Найман зуун ерэн есөн мянга таван зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө/ төгрөгийг давхардуулан эдлүүлсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрээгээр ажилласан 6 ажилтанд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт давхардуулан эдлүүлсэн 899,527.27 /Найман зуун ерэн есөн мянга таван зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/, ахлах нягтлан бодогч /Т.Дашжаргал/, нягтлан бодогч /Л.Адъяа/ ажилтнуудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газрын дарга /С.Мөнхзориг/ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2026\0316.SAG-24.Docx

1526200193



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 164/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 7 дугаар сард ээлжээр ажилладаг 17 ажилтанд 4,331,213.92 /Дөрвөн сая гурван зуун гучин нэгэн мянга хоёр зуун арван гурван төгрөг ерэн хоёр мөнгө/ төгрөгийн баяр ёслолын цагийн хөлс тооцож олгосноос 1,082,803.48 /Нэг сая наян хоёр мянга найман зуун гурван төгрөг дөчин найман мөнгө/ төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.9-т "Ээлжээр ажилладаг ажилтны ээлж долоо хоногийн амралтын болон нийтээр амрах баярын өдөр таарсан бол энэ хуулийн 109.2, 109.4-т заасан нэмэгдэл хөлс олгохгүй. Харин хамтын гэрээ, хамтын хэлэлцээрээр нэмэгдэл хөлс тогтоож болно." гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3 "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Баяр ёслолын цагийн хөлсийг тооцож олгоходоо илүү олгосон 1,082,803.48 /Нэг сая наян хоёр мянга найман зуун гурван төгрөг дөчин найман мөнгө/ төгрөгийг ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/, ахлах нягтлан бодогч /Т.Дашжаргал/, нягтлан бодогч /Л.Адъяа/ ажилтнуудаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын төрийн санд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын газрын дарга /С.Мөнхзориг/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ  
С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-24.Docx

1526200191



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 764/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА -СТА -ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 722 дугаар тогтоолоор баталсан "2025 оны бизнес төлөвлөгөөний эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-нөөс авлагыг 8,109,218,657.72 /Найман тэрбум нэг зуун есөн сая хоёр зуун арван найман мянга зургаан зуун тавин долоон төгрөг далан хоёр мөнгө/ төгрөгөөр, өглөгийг 1,399,873,649.78 /Нэг тэрбум гурван зуун ерэн есөн сая найман зуун далан гурван мянга зургаан зуун дөчин есөн төгрөг далан найман мөнгө/ төгрөг, нийт 9,509,092,307.50 /Есөн тэрбум таван зуун есөн сая ерэн хоёр мянга гурван зуун долоон төгрөг тавин мөнгө/ төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3-д "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", 71 дүгээр зүйлийн 8-д "Өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9206109  
ATA16037  
0000031411

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-43.Docx

1526181008



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 763/А0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/57/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн Жи мобайл ХХК-иас авах хугацаа хэтэрсэн авлагын зарим хэсгийг барагдуулах тухай ТУЗ-ын 2023 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 90/01 дүгээр тогтоолын дагуу авлагын зарим хэсэгт тооцон авсан Магнай трейд ХХК-ийн 600,000,000.00 /Зургаан зуун сая/ төгрөгийн шатахууны талноос, тайлант оны эцэст 344,160,000.00 /Гурван зуун дөчин дөрвөн сая нэг зуун жаран мянган/ төгрөгийн шатахууны талоны зарцуулагдаагүй үлдэгдэл бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрт авсан шатахууны талоныг дуустал бусад газраас шатахуун худалдан авахыг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-43.Docx

1526181006



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 762/АД150061

Улаанбаатар хот

САГ - 2026/57/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 5 байгууллагын 5,982,754.61 /Таван сая есөн зуун наян хоёр мянга долоон зуун тавин дөрвөн төгрөг жаран нэгэн мөнгө/ төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаанд өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

С.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316.SAG-43.Docx

1526181004



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 761/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/57/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд нийт 6 аймгийн 21 байгууллагын 53,216,525.33 /Тавин гурван сая хоёр зуун арван зургаан мянга таван зуун хорин таван төгрөг гучин гурван мөнгө/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-т "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант хугацаанд авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /С.Адъяасүрэн/, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /М.Баярсайхан/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ МОНГОЛ ХӨЛӨГ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
П.ЧАНЦАЛДУЛАМ

С.ТУНГАЛАГ